Чихрийн шижин хэвшинж 2-той ба чихрийн шижингүй эрэгтэйчүүдийн шодойн хөвчрөл сулралыг харьцуулсан дүн

Ж.Пүрэвдолгор[1], Н.Нансалмаа[2], С.Сайнбилэг[3]

[1]Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг
[2]Адам эмнэлэг
[3]АШУҮИС
Email: puugii_17@yahoo.com, Утас:99011128

Түлхүүр үг:
Чихрийн шижин
Глюкоз
Шодойн хөвчрөл

Товч утга:
Үндэслэл: Чихрийн шижин өвчний үед тохиолдох захын мэдрэлийн эмгэг болон вегататив мэдрэлийн эмгэг нь шодойн хөвчрөл сулралын алдагдалд хүрэхэд шууд нөлөөлдөг[3] төдийгүй энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажил манай оронд харьцангуй хомс байгаа судалгаа хийх үндэслэл боллоо. **Зорилго:** Чихрийн шижин хэв шинж 2-той, чихрийн шижингүй эрэгтэйчүүдийн шодойн хөвчрөл сулралыг харьцуулан судлах **Судалгааны материал, арга зүй:** Судалгаанд агшингийн, дескриптив судалгааны арга ашигласан. Судалгаанд 2017-2018 онд Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Диабетийн төвөөр үйлчлүүлсэн, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн ЧШХШ 2-той 30 эрэгтэй, ЧШ-гүй 30 эрэгтэй үйлчлүүлэгчийг сонгон хамруулсан. **Үр дүн:** ЧШХШ 2-той эрэгтэйчүүдийн ШХОУУ дундаж оноо 17.13±3.64, харин ЧШ-гүй эрэгтэйчүүдийн ШХОУУ дундаж оноо 20.07±2.35 байна. ЧШХШ 2-той эрэгтэйчүүдийн 13.3% нь ШХОУУ-ний оноогоор үнэлэхэд хэвийн, 86.7% ШХС-тай үнэлэгдлээ. **Дүгнэлт:** Чихрийн шижинтэй эрэгтэйчүүдийн 13.3% нь ШХОУУ-ний оноогоор үнэлэхэд хэвийн, 86.7% ШХС-тай байв. ЧШ-гүй эрэгтэйчүүдийг ШХОУУ-ний оноогоор үнэлэхэд 26.6 %хэвийн, 73.4% ШХС-тай үнэлэгдлээ. ЧШ-тэй эрэгтэйчүүдэд хөнгөн, дунд, хүндэвтэр зэргийн ШХС тохиолдож байгаа бол ЧШ-гүй эрэгтэйчүүдэд хөнгөн зэрэг илүү байна.

Үндэслэл: Монголд чихрийн шижингийн тархалт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа бөгөөд 1999 онд хийгдсэн чихрийн шижингийн тархалтыг анхны судалгаагаар 35-аас дээш насны хүмүүсийн 3.1% чихрийн шижинтэй, 9.2% чихрийн шижингийн урьдал байдалтай байсан бол халдварт бус өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын 2005 ба 2009, 2013 оны судалгаагаар чихрийн шижингийн тархалт 8.2% ба 6.5%, чихрийн шижингийн урьдал байдлын тархалт 12.2% ба 9.4% болж нэмэгдсэн[1]. Чихрийн шижингийн невропатийн тархалтыг тодорхойлох судалгаагаар чихрийн шижинтэй хүмүүсийн 71% захын невропати, 65.1% хөлсний булчирхайн вегетатив невропати, 52.7% зүрх судасны вегетатив невропати, 54.5-84.1% шээс бэлгийн замын вегетатив невропати, эрэгтэйчүүдийн 76.8% шодойн хөвчрөл сулралын зовиуртай байна[2]. Түүнчлэн чихрийн шижин өвчний үед тохиолдох захын мэдрэлийн эмгэг болон вегататив мэдрэлийн эмгэг нь шодойн хөвчрөл сулралын алдагдалд хүрэхэд шууд нөлөөлдөг[3] төдийгүй энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажил манай оронд харьцангуй хомс байгаа судалгаа хийх үндэслэл боллоо.

Зорилго: Чихрийн шижин хэв шинж 2-той, чихрийн шижингүй эрэгтэйчүүдийн шодойн хөвчрөл сулралыг харьцуулан судлах

Судалгааны материал, арга зүй: Судалгаанд агшингийн, дескриптив судалгааны арга ашигласан. Судалгаанд 2017-2018 онд Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Диабетийн төвөөр үйлчлүүлсэн, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн ЧШХШ 2-той 30 эрэгтэй, ЧШ-гүй 30 эрэгтэй үйлчлүүлэгчийг сонгон хамруулсан. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл шодойн хөвчрөл сулралыг шодойн хөвчрөлийн олон улсын үнэлгээ асуумж (IIEF)-аар4, биеийн жин, өндөр, бүсэлхийн тойрог, цусны даралтыг стандарт хэмжилтээр, цусан дахь глюкоз, холестерин, триглицерид хэмжээг биохимийн Robonik автомат анализатораар тодорхойлов. Судалгааны мэдээллийг SPSS -25 программ ашиглан боловсруулав. Статистик таамаглал үнэн магадлалтайг $p<0.05$ үед статистик ач холбогдол бүхий хэмээн дүгнэсэн.

Үр дүн: *Ерөнхий мэдээлэл:* Судалгаанд нийт ЧШХШ 2-той 30, ЧШ-гүй 30 эрэгтэй оролцсон ба дундаж нас 44.72±5.71, 43.26±8.47, артерийн даралт 128.47±17.11, 124.90±21.75 мм муб ойролцоо байлаа. Судалгаанд оролцогчдын бие махбодийн үзүүлэлтийг авч үзэхэд биеийн жингийн индекс 29.24±5.8, 26.80±3.44 кг/м2 хэвийн дундаж хэмжээнээс ЧШ-тэй эрэгтэйчүүд өндөр (p=0.061) статистикийн ялгаагүй байна. Харин бүсэлхий тойрог 98.58±11.64, 89.57±10.61 (p=0.002), ЧШ-тэй эрэгтэйчүүдэд ЧШ-гүй эрэгтэйчүүдээс өндөр байгаа статистик ач холбогдолтой байна. ШХОУУ-ний дундаж оноо 17.13±3.64, 20.07±2.35 байгаа ЧШ-тэй эрэгтэйчүүдэд бага байгаа, ЧШ үргэжилсэн жил 8.41±2.56 p<0.005 статистик ач холбогдолтой байна

Судалгаанд оролцсон ЧШ-тэй, ЧШ-гүй эрэгтэйчүүдийн лабораторын шинжилгээний зарим үзүүлэлтийг харьцуулж үзэхэд өлөн үеийн цусны глюкозын дундаж ЧШ-тэй эрэгтэйчүүдэд 10.19±5.43 ммоль/л, ЧШ-гүй эрэгтэйчүүдэд 4.94±0.69 ммоль/л (p=0.00001), холестрол 3.88±1.43 ммоль/л, 2.05±0.96 ммоль/л (p=0.00001), триглицерид 2.34±0.48 ммоль/л, 1.55±0.47 ммоль/л (p=0.0001) статистик ач холбогдолтой байна.

Шодойн хөвчрөл сулралын үнэлгээ: ЧШХШ 2-той эрэгтэйчүүдийн ШХОУУ дундаж оноо 17.13±3.64, харин ЧШ-гүй эрэгтэйчүүдийн ШХОУУ дундаж оноо 20.07±2.35 байна. ЧШХШ 2-той эрэгтэйчүүдийн 13.3% нь ШХОУУ-ний оноогоор үнэлэхэд хэвийн, 86.7% ШХС-тай үнэлэгдлээ. ШХС-тай ЧШ-тэй эрэгтэйчүүдийн 53.0% нь хөнгөн, 34% дунд, 11.5% хүндэвтэр зэргийн үнэлгээтэй байна. ЧШ-гүй эрэгтэйчүүдийг ШХОУУ-ний оноогоор үнэлэхэд 26.6% хэвийн, 73.4% ШХС-тай үнэлэгдлээ. ШХС-тай ЧШ-гүй эрэгтэйчүүдийн 95.3 % хөнгөн, 4.5% дунд зэргийн ШХС-тай байгаа нь ЧШ-тэй эрэгтэйчүүдэд хөнгөн, дунд, хүндэвтэр зэргийн ШХС тохиолдож байгаа бол ЧШ-гүй эрэгтэйчүүдэд хөнгөн зэрэг илүү байна.

Хэлцэмж: Тайваны судлаач М-Ди Ши нарын 2014 онд хийгдсэн судалгаагаар нийт 240 хүн хамрагдсан ба 40–70 насныхан байсан ба дундаж нас 51.62±7.76 жил байсан. Уг судалгаанд 135 ЧШ-тэй, 105 ЧШ-гүй эрэгтэйчүүд оролцсон. ШХОУУ-ний дундаж оноо 21.99±2.34 ба 134 (55.8%) нь шодойн хөвчрөл сулралтай, 150 (62.5%) нь бодисын солилцоо алдагдах хам шинжтэй, 98 (40.8%) нь артерийн даралт ихсэлттэй, 47 (19.6%) нь дислипидемитэй, 128 (53.3%) нь таргалалттай (БЖИ <27), 57 (23.8%) нь илүүдэл жинтэй байна[5]. Тайваны судлаач М-Ди Ши нарын судалгаагаар ШХОУУ-ний дундаж оноо 21.99±2.34 ба 134 (55.8%) нь шодойн хөвчрөл сулралтай үнэлэгдсэн бол манай судалгаагаар чихрийн шижинтэй эрэгтэйчүүдийн ШХОУУ дундаж оноо 17.13±3.64, харин чихрийн шижингүй эрэгтэйчүүдийн ШХОУУ дундаж оноо 20.07±2.35 өндөр байна. Уг судалгааны 47 (19.6%) нь дислипидемитэй, 128 (53.3%) нь таргалалттай (БЖИ <27), 57 (23.8%) нь илүүдэл жинтэй байгаа манай судалгаатай ойролцоо байна. Хятадад хийгдсэн ЧШ-тэй 175 эрэгтэйчүүдийг хамруулсан судалгаагаар шодойн хөвчрөл сулралд нас, чихрийн шижин үргэжилсэн жил хамааралтай болохыг тэмдэглэсэн нь бидний судалгаатай адил байна. Мөн уг судалгаагаар шодойн хөвчрөл сулралд БЖИ<25 кг/м^2, цусны даралт ихсэх өвчин, нийгэм эдийн засгийн байдал нөлөөлдөг гэсэн дүгнэлт гарсан. Судалгаанд оролцогчдыг ШХСОУУ-ний оноогоор үнэлэхэд 9.8% хэвийн, 30.9% хөнгөн, 18.9% дунд зэргийн, 13.7% хүндэвтэр, 27.4 хүнд зэргийн ШХС-тай байсан.6 Бидний судалгаанд чихрийн шижинтэй эрэгтэйчүүдийн 13.3 хувь нь ШХОУУ-ний оноогоор үнэлэхэд хэвийн, 86.7% ШХС-тай үнэлэгдлээ. Хятадад хийгдсэн судалгаатай ШХОУУ-гээр 9.8% хэвийн, 90.2% нь ШХС-тай байгаа нь оролцооо байна.

Дүгнэлт: Чихрийн шижинтэй эрэгтэйчүүдийн 13.3% нь ШХОУУ-ний оноогоор үнэлэхэд хэвийн, 86.7% ШХС-тай байв. ЧШ-гүй эрэгтэйчүүдийг ШХОУУ-ний оноогоор үнэлэхэд 26.6 %хэвийн, 73.4% ШХС-тай үнэлэгдлээ. ЧШ-тэй эрэгтэйчүүдэд хөнгөн, дунд, хүндэвтэр зэргийн ШХС тохиолдож байгаа бол ЧШ-гүй эрэгтэйчүүдэд хөнгөн зэрэг илүү байна.

Ном зүй:

1. *Халдварт бус өвчин, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийг тогтоох шаталсан тархалтын судалгаа -2009 Улаанбаатар 2005 хуудас 19*
2. *Сайнбилэг С. Сувд Ж, Цагаанхүү Г, Алтайсайхан Х, Чихрийн шижин өвчний мэдрэлийн хүндрэлийн асуудалд. ЭМШУИС-ийн Эрдмийн чуулган-51 Эрүүл Мэндийн Шинжлэх Ухаан сэтгүүл 2009; 11 : 170-172*
3. *Lunenfeld B.Endocrinology of the aging male. Minerva Ginecol 2006,58(2):153-170*
4. *Relationship between serum sex steriods and Aging Male Symptoms score and International Index of Erectile Function. Urology. 2005, 66 (3):597-601*
5. *M-D Shi, J-K Chao. The connection between type 2 diabetes and erectile dysfunction in Taiwanese aboriginal males. Int J Impot Res. 2014 Nov-Dec;26(6):235-40.*
6. *Dai S, W. Wang ang M, Morrison H. Erectile dysfunction and fruit/vegetable consumption among diabetic Canadian men. Urology. 2013 Dec; 82(6):1330-5. doi: 10.1016/j.urology.2013.07.061.*

Erectile dysfunction among Mongolians with type 2 diabetes

Purevdolgor.J[1], Nansalmaa.N[2], Sainsbileg.S[3]

[1]Third State Hospital, Ulaanbaatar, Mongolia
[2]ADAM clinic, Ulaanbaatar, Mongolia
[3]Department of Endocrinology, School of Medicine, MNUMS
Emai:puugii_17@yahoo.com, Tel: 99011128

Introduction: Diabetes is associated with peripheral and autonomic neuropathy and both of these can contribute to erectile dysfunction (ED). The frequency of ED among type 2 diabetic patients are reporting highly.
Objective: The aim of this study was evaluate frequency and risk factors of ED among T2DM patients and non DM.
Methods: The cross–sectional study was T2DM aged 30-59 years old for the patients. Finally, we had using systematic random sampling to divide into two groups which were T2DM group (N=30) and non DM group (N=30). ED was diagnosed by the International Index Erectile Function (IIEF5) questionniare. Erectile function status of the subjects was classified: Normal erectile function (score > 21), mild ED (score 17- 21), mild-to-moderate ED (score 12-16), moderate ED (score 8-11), and severe ED (score < 8). Laboratory evaluation of TC, TG, Glu, level was done. Risk factors of ED were evaluated by questionnaire.
Results: The mean age of T2DM group's male patients were 42.87±5.81 years old and mean diabetes duration was 7.64±4.40 years. By the IIEF-5 questionnaire T2DM patients with normal erectile function was 16%, with ED was 84% (Mild to moderate ED 22.77% + with Moderate ED 45.53% + with serious ED was 24.74 + with Severe ED 6.89%). The ED was correlated with mean age (OR=0.346 p=0.042), The mean age of non DM group's male patients were 44.72±5.71, be the IIEF-5 questionnaire non DM group patients with normal erectile function was 26.6%, with ED was 73.4% , and 95,3% who was mild to moderate, 4.5% who was moderate ED. There is a mild, moderate and severe ED with men with T2DM while men with non DM groups are more likely to be mild.